



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03/5 № 3/455
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар "Багануурын дулааны станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

САГазрын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 260512

Үндэсний Аудитын Газар
Засгийн газрын Үбайр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс
Цахим хуудас: www.audit.mn

“Ай Жэй Эй Эйч” Аудит ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас: 99040059, 450279
Цахим хаяг:
ljah_audit_2008@yahoo.com
Аудитор: Н. Уранчимэг
Утас: 91093898

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны 12 сарын 31-ээр тасалбар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/15/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 10-аас 2017 оны 03 дугаар сарын 15-ыг хүртэл хийхээр төлөвлөн “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Л.Оюунцэцэг, аудитор Н.Уранчимэг, аудиторов туслах Но.Уранчимэг, Г.Түмэнцэцэг нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны төсвийн санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 15-нд “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК нь гүйцэтгэлийн аудитыг 2017 оны 03 дугаар сарын 05-аас 2017 оны 03 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын “Эрчим хүчний тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн аудитын тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-ууд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан Эрчим хүчний хорооноос гаргасан тушаал шийдвэр, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна. 2016 оны 02 дугаар сарын 01-ээс Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэрээр дулааны эрчим хүчний үнэнд орсон өөрчлөлтийг дагаж мөрдсөн байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь “Хүний хөгжил, дэвшилтэт технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан ДЭХ-ээр тасралтгүй найдвартай хангана” гэж эрхэм зорилгоо тодорхойлон ажиллаж байна. Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх зарчмыг тодорхойлсон нь

компанийн үйл ажиллагааны чиглэл удирдамж болж байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана” гэж заасны дагуу компанийн гүйцэтгэх захирал нь удирдаж эд хөрөнгийг захиран зарцуулж байна.

Компани нь 1980 онд байгуулагдаж Төрийн өмчийн хорооны 2008 оны 02-р сарын 28-ны өдрийн 88-р тогтоолоор бие даасан хуулийн этгээд Төрийн өмчит хувьцаат компани болж Багануур дүүргийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад дулааны эрчим хүчийг хүргэх үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос дулааны эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах 3 тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны бизнес төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 34 дүгээр тушаалаар баталж түүний дагуу ХААН, ХАС, Голомт, Капитал, Төрийн банкны дансаар дамжуулан зарцуулж байна.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-тай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан дүрмийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,

Хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Багануур дүүргийн дулааны станц ТӨХК-ний 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан горим, сорил 16-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд 2008 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг НББ-ийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу бэлтгэсэн байна. Тус байгууллага нь Ординат ХХК-ний “Венециа” программ ашиглаж байна.

Материаллаг байдал:

Материаллаг байдлыг төлөвлөлтийн үе шатанд 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн зардлын 1 хувь буюу 33,007.9 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд 2016 оны 4 дүгээр улирлын нийт зардлын 1 хувиар тооцоход 59,788.3 мянган төгрөг байна. /ТАБ-СТА-А-4 /

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэхгүй байгаа ба дотоод хяналтын ажилтан нь хуулийн мэргэжилтэй, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт төдийлөн хийдэггүй гэж удирдлагууд тайлбарлаж байна.

Борлуулалтын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь 2016 онд 155.9 мянган Гкалл дулаан борлуулан 4,505.0 сая төгрөгийн борлуулалтын орлого, 116.9 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлого олж, улсын төсвөөс 1,100.0 сая төгрөгийн татаас авч 5,978.8 сая төгрөгийг үйл ажиллагаанд, 116.6 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардалд зарцуулж 373.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант жилд борлуулалт /дулаан үйлдвэрлэлт Гкалл/ өмнөх оноос 6.2 мянган Гкалл ДЭХ илүү үйлдвэрлэсэн ба орлогын төлөвлөгөөг 101.2 хувь буюу 52.0 сая төгрөгөөр илүү биелүүлсэн нь үйлдвэрлэлт өссөнтэй холбоотой байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 01-ээс цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг 10-15%-аар нэмэгдүүлсэн нь төлөвлөгөө биелэхэд нөлөөлсөн байна гэж үзэж байна

Тайлант жилд үйл ажиллагаандаа 5,978.8 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардалд 116.6 сая төгрөг зарцуулсан нь 2015 оноос 3.2%-иар буюу 187.9 сая төгрөгөөр нэмэгдэж төлөвлөгөөнөөс 12.7%-иар буюу 673.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Эрчим хүчний зохицуулах хорооноос 1тн нүүрсний үнийг 13,200 төгрөгөөр баталсан үнийг мөрдөж чадаагүй 25,500 төгрөгөөр худалдан авснаас нүүрсний зардал нь 707.2 сая төгрөгөөр, нүүрсний тээврийг бусдын тээврээр гүйцэтгүүлснээс 19.4 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс гадуур 38.6 сая төгрөгөөр сэлбэг хэрэгсэл худалдан авснаас зардал өссөн байна.

Тайлант жилд өмнөх оноос алдагдал нь 22.7% буюу 265.4 сая төгрөгөөр буурсан байна. 373.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласны гол шалтгаан нь зуны улиралд халаалт зогсож аж ахуйн нэгж, айл өрхүүдэд хэрэглээний халуун усыг тогтмол өгсөн, түүхий эд материалын зардал өссөн, зуны саруудад банкнаас 350.0 сая төгрөгийн зээл авч зарцуулсан зэргээс болж алдагдал хүлээсэн байна гэж дүгнэж байна.

Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан байна.

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журам батлагдсан байна.

Аудитын хугацаанд Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь шилэн дансны вэбсайтад шилэн дансаа нээж 2016 оны 1-12 сарын төсөв ба гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, худалдан авах ажиллагааны төсөв гүйцэтгэл, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэлийг тухай бүр, улирал бүрээр, 2016 оны санхүүгийн тайланг хагас жилээр тус тус шивж оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 16-г гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тайлант жилд аж ахуйн нэгж байгууллагаас авах авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлийн зардлаараа анхны өртгөө нөхсөн их хэмжээний хөрөнгүүдийг данснаас хасах эсвэл дахин үнэлж ашиглах тухай санал, шийдвэр гаргаагүй, НБББББ-тээ өөрчлөлт оруулаагүй эдгээр алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгжээс нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэх чиглэлээр хяналт хийгдээгүй байна.

Тайлант жилд авлага нь 64.4 сая төгрөгөөр нэмэгдсэний 96.8 хувийг дулааны эрчим хүчний авлага эзэлж байна. Нийт авлагын 183.2 сая төгрөг нь айл өрхөөс авах авлага, 118.6 сая төгрөг нь ААН-ээс авах авлага, 40.7 сая төгрөгийн авлага нь “Багануур УС” ОНӨААТҮГ-аас авах дулааны авлага байна.

Нийт өглөг нь өнгөрсөн оноос 170.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Багануур ХК-ний нүүрс усны өглөг 2,743.8 сая төгрөг буюу өглөгийн 89.7%-ийг эзэлж байна. 2016 оны 12 дугаар сараас Эрчим хүчний зохицуулах хорооноос 1тн нүүрсний үнийг 11,000 төгрөг болгож шийдвэрлэсэн нь Багануур ХК-ний өглөгийг барагдуулах боломжтой болсон гэж удирдлагууд тайлбарлаж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын орлогоос 2015 онд 38.8%, 2016 онд 26.6%-иар илүү байгаа нь алдагдалтай ажиллахад хүргэсэн байна. Мөн дулааны эрчим хүчний үнэ тарифын талаар баримталж байгаа бодлогын дагуу бүтээгдэхүүний өртгөөс доогуур үнээр борлуулж байгаагаас үүдэлтэй алдагдал, орлогын хомсдол, хуримтлагдсан өр, мөнгөн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө барагдуулж чаддаггүй өглөгөө хоорондын тооцоогоор хааж ирсэн байдалтай байна. Тайлант онд авлагын барагдуулалт муу байгаагаас авлага 19.5%-аар нэмэгдсэн нь богино хугацаат өглөгөө барагдуулахгүй байгаа гол шалтгаан болсон байна. Эдгээр байдал нь компанийн төлбөрийн чадварыг доройтуулж, санхүүгийн хүндрэл бий болох эрсдэлд хүргэж байна. Мөн Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өндөр байгаа нь тэтгэвэр тэтгэмжийн зардал өндөр, тэтгэвэрт гарсан ажилтны буцалтгүй тэтгэмжийг гарсан үед нь олгож чадахгүй өглөг үүсгэсээр байна.

Цаашид алдагдлыг бууруулах зорилгоор үнэ тарифыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны бус зардлыг багасгаж үргүй зардал гаргахгүй байх, авлага өглөгийг барагдуулах, төлөх эх үүсвэргүй өр, авлагыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх шаардлагатай байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн элэгдэл, үйл ажиллагааны орлого, зарлага, цалин, НД-ын тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 60,0 хувь, мөнгөн хөрөнгийн 70 хувь, нийт хөрөнгийн 50 хувийг эзэлж байна.

Багануур дулааны станц ТӨХК-ний захиргаа, ҮЭХ хооронд байгуулсан хамтын гэрээний 6.10-д “Эрчим хүчний тэргүүний ажилтанд нэг сард 10,000 төгрөг, гавьяат ажилтан, төрийн шагналтанд 10000 төгрөг, улсын ба хөдөлмөрийн баатарт 15000 төгрөгөөр тооцож жилд нэг удаа олгоно. Энэ заалт нь ҮОМШӨ, хурц хордлогын улмаас

группт байгаа хүмүүс, ахмад настанд нэг адил хамаарна” гэсний дагуу тайлант жилд 57 ажилтанд сар бүр 10.0 мянган төгрөг нийт 6,170.0 мянган төгрөг олгосон байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитын явцад илэрсэн зүйлүүд, аудитаар хөндөгдсөн гол асуудлууд ба тэдгээрийг шийдвэрлэсэн байдлыг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв.

Үүнд: Материаллаг бус дараах алдаа, зөрчил илэрч байна.

1.Тайлант жилд аж ахуйн нэгж байгууллагаас авах 117,774.3 мянган төгрөгийн авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад тооцоо нийлсэн актыг бүрдүүлэх байдлаар залруулав. Цаашид алдааг давтахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

2.Тайлант жилд бидний түүвэрлэж үзсэн хөрөнгөөс 15 нэр төрлийн 174,996.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа нь дуусч элэгдлийн зардлаараа анхны өртгөө нөхсөн байна. НББОУС-ын 16.67-д "ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгийг данснаас хасна", ТБОНӨТХуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоож ашиглана" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид үндсэн хөрөнгийг данснаас хасах, цаашид дахин ашиглах тухай заасан хуулийг хэрэгжүүлэх талаар удирдлагад менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

3.Тус байгууллагын НБББББ нь 2008 онд боловсруулагдсан бөгөөд одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн стандарт бусад холбогдох журам зааварт нийцэхгүй байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 53 тоот тогтоолоор баталсан журмын хавсралтын 3.4-т "Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг НББОУС 16-д заасан болон компанийн НБББББ-т тусгаж мөрдөнө", 3.9-д "Хөрөнгө нь биет байдлын хувьд элэгдэж цааш ашиглагдах боломжгүй болсон эсвэл элэгдэл тооцох ашиглалтын хугацааны эцэст үлдэх өртөгтэй байж болно. Хэрэв үлдэх өртөгтэй байх бол энэ талаар компанийн НБББББ-т тусгана" гэж заасан тул 2008 онд боловсруулсан НБББББ-ийг хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид НБББББ-ийг холбогдох стандарт, заавар журмын дагуу боловсруулан дагаж мөрдөхийг удирдлагад зөвлөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Байгууллагын 2016 оны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад яригдсан асуудлууд болон менежментийн захидлаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзнэ. Мөн тайлант жилийн хоорондын тооцоогоор хааж байгаа өглөг авлагын баримтыг гүйцээж мөшгин шалгаж амжаагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар агуулга шинж чанарын хувьд материаллаг бус нийт 292.7 сая төгрөгийн алдаа зөрчил, илэрсэн ба дахин давтахгүй байхыг зөвлөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК нь 2016 оны санхүүгийн тайланд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-аас хийсэн аудитаар 6 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг 60 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Багануур дүүргийн Дулааны станц ТӨХК-ний 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд 5 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.



**БАГАНУУРЫН
ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Авлагын талаар

Асуудал 2
Үндсэн хөрөнгийн талаар

Асуудал 3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
бичгийн талаар

2017 оны 03 дугаар сарын 13

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Багануурын Дулааны станц ТӨХК-ний удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Багануурын Дулааны станц ТӨХК-ний санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант жилд бидний түүвэрлэж үзсэн хөрөнгөөс 15 нэр төрлийн 174,996.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа нь дуусч элэгдлийн зардлаараа анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББОУС-т заасан болон ТБОНӨТХуулийг хэрэгжүүлж ажиллах.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байдал, хэмжилт, тохиолдсон байх, толилуулга ба илчлэг байх эдгээр батламж мэдэгдлийг зөрчих

Төсвийн захирагчийн хариу

2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/194 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Асуудал 3: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын 2008 онд боловсруулагдсан НБББББ нь одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн стандарт бусад холбогдох журам зааварт нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид НБББББ-ийг өөрчлөн шинэчилж мөрдөхийг зөвлөж байна.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/194 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

**БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,508,497.59	11,160,694.73
Дансны авлага	286,627,353.08	342,472,135.19
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага	2,578,699.51	11,143,020.97
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	207,608,863.63	221,649,360.88
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		719,999.99
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	501,323,413.81	587,145,211.76
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	6,950,012,234.54	9,754,760,069.37
Биет бус хөрөнгө	10,476,944.76	-
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,960,489,179.30	9,754,760,069.37
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,461,812,593.11	10,341,905,281.13
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,955,741,189.88	3,127,065,071.58
Цалингийн өглөг		
Татварын өр	67,384,397.37	55,412,551.30
НДШ-ийн өглөг	32,121,678.63	-
Богино хугацаат зээл	250,000,000.00	300,000,000.00
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	19,620,576.70	3,245,241.72
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	11,980,800.00	4,735,200.00
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,336,848,642.58	3,490,458,064.60
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр	14,285,920.61	15,293,567.00
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	14,285,920.61	15,293,567.00
Өр төлбөрийн нийт дүн	3,351,134,563.19	3,505,751,631.60
Эздийн өмч		
Өмч : - төрийн	6,291,517,841.35	6,291,517,841.35
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	697,879,621.79	697,879,621.79
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг	3,543,230,021.12	6,643,225,708.12
Хуримтлагдсан ашиг	(6,421,949,454.34)	(6,796,469,521.73)
Тайлант үеийн ашиг	(639,936,871.11)	(374,520,067.39)
Өмнөх үеийн ашиг	(5,782,012,583.23)	(6,421,949,454.34)
Эздийн өмчийн дүн	4,110,678,029.92	6,836,153,649.53
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,461,812,593.11	10,341,905,281.13

**БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ОРЛОГЫН ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	3,990,592,021.26	4,505,054,622.75
Борлуулалтын өртөг	5,542,326,415.15	5,705,088,101.32
Нийт ашиг (алдагдал)	(1,551,734,393.89)	(1,200,033,478.57)
Түрээсийн орлого	1,499,651.00	1,525,524.00
Хүүний орлого	592,322.43	1,015,239.50
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	1,336,073,723.57	1,214,400,903.62
Орлогын дүн	1,338,165,697.00	1,216,941,667.12
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	216,886,245.59	208,022,438.83
Санхүүгийн зардал	31,628,250.20	65,722,138.80
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)	(170,686,906.05)	(116,574,507.97)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(632,770,098.73)	(373,410,897.05)
Орлогын татварын зардал	7,166,772.38	1,109,170.34
Татварын дараах ашиг (алдагдал)	(639,936,871.11)	(374,520,067.39)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(639,936,871.11)	(374,520,067.39)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	(639,936,871.11)	(374,520,067.39)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	нэмж төлөгдсөн капитал	хөрөнгийн дахин үнэлгээний	гадаад валютын хөрөнхөөр хөрөнхөөр	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35			697,879,621.79		3,538,304,658.92	(5,771,919,868.84)	4,755,782,253.22
2	Нягтлан бодох өүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задрал							(10,092,714.39)	(10,092,714.39)
3	Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	-	-	697,879,621.79	-	3,538,304,658.92	(5,782,012,583.23)	4,745,689,538.83
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(639,936,871.11)	(639,936,871.11)
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-					4,925,362.20		4,925,362.20
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-				-
9	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	-	-	697,879,621.79	-	3,543,230,021.12	(6,421,949,454.34)	4,110,678,029.92
10	Нягтлан бодох өүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задрал							-	-
11	Залруулсан үлдэгдэл	6,291,517,841.35	-	-	697,879,621.79	-	3,543,230,021.12	(6,421,949,454.34)	4,110,678,029.92
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(374,520,067.39)	(374,520,067.39)
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт						3,099,995,687.00		3,099,995,687.00
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
17	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,291,517,841.35	-	-	697,879,621.79	-	6,643,225,708.12	(6,796,469,521.73)	6,836,153,649.53

**БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ
АУДИТ ХИЙГДСЭН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	2015.12.31	2016.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,998,603,674.64	4,468,730,060.05
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,869,304,120.93	3,329,212,473.42
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,699,835.00	24,635,897.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого	1,100,000,000.00	1,100,000,000.00
Бусад мөнгөн орлого	22,599,718.71	14,881,689.63
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Мөнгөн зарлагын дүн (-)	3,767,489,643.96	4,337,455,002.41
Ажиллагчдад төлсөн	1,323,765,438.71	1,470,193,958.23
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	360,188,632.78	424,755,746.03
Бараа материал худалдан авахад төлсөн	1,296,278,533.61	914,952,443.16
Ашиглалтын зардалд төлсөн		460,447,300.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	94,783,139.30	178,249,463.41
Хүүний төлбөрт төлсөн	26,882,746.36	60,816,738.80
Татварын байгууллагад төлсөн	226,021,889.52	465,578,355.05
Даатгалын төлбөрт төлсөн		1,953,000.00
Бусад мөнгөн зарлага	439,569,263.68	360,507,997.73
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	231,114,030.68	131,275,057.64
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	592,864.32	1,015,239.50
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	592,864.32	1,015,239.50
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	193,224,922.00	175,638,100.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	114,974,922.00	175,638,100.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	78,250,000.00	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(192,632,057.68)	(174,622,860.50)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	390,901,627.00	391,340,500.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	390,901,627.00	391,340,500.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	434,532,539.92	341,340,500.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	434,532,539.92	341,340,500.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(43,630,912.92)	50,000,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,148,939.92)	6,652,197.14
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,657,437.51	4,508,497.59
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,508,497.59	11,160,694.73